Настны сэтгэл гутралын шалтгааныг илрүүлэх судалгаа

А.Аюурзана[1], М.Уранзаяа[2], Б.Батхүү[1]

[1]АШУҮИС, АУС, ӨАУ тэнхим
[2]АШУҮИС, 4-р дамжааны оюутан
Цахим шуудан: ayurzana@mnums.edu.mn, Утас: 98010138

Түлхүүг үг:

Сэтгэл гутрал
Настан
Уй гашуу
Ганцаардал
Архаг өвчин

Товч утга:

Үндэслэл: 2030 он гэхэд 65 ба түүнээс дээш насны өндөр настангууд Монгол улсын хэмжээнд оршин суугчдын 11.9 хувийг бүрдүүлэх бөгөөд 2050 онд энэ хүн ам 21.1%-д хүрнэ. **Зорилго:** Настны сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх зорилго тавилаа. **Зорилт:** Энэхүү судалгаа нь оролцогчдоос сэтгэл гутралыг илрүүлэх улмаар сэтгэл гутралд нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоох зорилтыг тавилаа. **Арга, аргачлал**: Уг судалгаанд Үлэмж-Ээж хувийн үүдэн эмнэлэгт үзүүлсэн үйлчлүүлэгчдээс сэтгэл гутралыг илрүүлэх асуумж авч түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүллээ. Сэтгэл гутралын шалтгаанд гэр бүлийн хэн нэгнийг алдсан 37%, ганцаардал 23.2%, хөгшрөлтөөс үүсэх архаг өвчлөл 11.2%, тэтгэвэрт гарснаас хэнд ч хэрэггүй мэт санагдах 9.7%, үр хүүхэдтэйгээ муу харилцаатай 5.4%, материаллаг хэрэгцээний дутагдал 5.2% байсан нь тус тус тодорхойлогдлоо. **Хэлцэмж**: Когорт судалгаагаар сэтгэл гутрал бүх оролцогчдод илэрч байсан бөгөөд үүний 48%-нь уй гашуу тайлах эмчилгээгээр илааршсан байна. **Дүгнэлт**: Хагацлын дараах уй гашуу сэтгэл гутралыг илүүтэй үүсгэж байгаа бөгөөд уй гашуу тайлах эмчилгээ хийх үр дүнтэй байх магадлалтай.

Үндэслэл: 2030 он гэхэд 65 ба түүнээс дээш насны өндөр настангууд Монгол улсын хэмжээнд оршин суугчдын 11.9% хувийг бүрдүүлэх бөгөөд 2050 онд энэ хүн ам 21.1 %-д хүрнэ.[1] Ахмад настнуудын 60% нь доод тал нь нэг архаг өвчтэй, 42% нь хоёроос доошгүй архаг өвчтэй байдаг архаг өвчинд харьцангуй их өртдөг[1]. Сэтгэлийн хямрал нь өндөр настнуудын дунд ноцтой асуудал бөгөөд нийгмийн эрүүл мэндийн томоохон асуудал юм.[2,3] 65 ба түүнээс дээш насны оршин суугчдын дунд сэтгэл гутралын тархалт 5-15% байна гэж тооцоолж байгаа бөгөөд 2020 он гэхэд энэ хүн амын өвчлөлийн хоёр дахь гол шалтгаан болох төлөвтэй байна.[4,5] Настны сэтгэл гутралын шалтгаанд улс орон бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд манай орны хувьд ямар шалтгаан нөлөөж байгааг судлах нь нийгмийн эрүүл мэндийн настанд чиглэсэн интервенц зохиоход ач холбогдолтой байгаа нь энэхүү судалгаа хийх үндэслэл боллоо.

Зорилго: Бидний судалгааны зорилго нь настны сэтгэл гутрал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тогтооход чиглэгдлээ.

Зорилт:

1. Судалгаанд оролцогчдод сэтгэл гутралыг илрүүлэх
2. Судалгаанд оролцогчдын сэтгэл гутралд нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоох

Арга, аргачлал: Судалгааны загвар: Энэхүү судалгааны мэдээллийг 2019-2021 оны хооронд Үлэмж-Ээж хувийн үүдэн эмнэлгээр үзүүлсэн нийт 3960 настны сэтгэл гутралыг илрүүлэх олон улсын асуумжийг ашиглан авлаа. Статистик боловсруулалтыг хийхдээ түүврийн логистик регрессийг аргыг ашиглан (n=3960) итгэх интервалыг (CI) тооцоолж гаргалаа.

Үр дүн: Улаанбаатар хотын (2019-2021он) Баянгол дүүрэгт байрлах Үлэмж-Ээж хувийн үүдэн эмнэлгээр үйлчлүүлсэн нийт 3960 үйлчлүүлэгчдээс сэтгэл гутралын илрүүлэх олон улсын асуумжийг бөглүүлэхэд 206 хүнд буюу 5.2% (95% CI: 5.1-6.0%) сэтгэл гутрах эмгэгтэй гэж үнэлэгдлээ. Сэтгэл гутралын шалтгаанд гэр бүлийн хэн нэгнийг алдсан 37%, ганцаардал 23.2%, хөгшрөлтөөс үүсэх архаг өвчлөл 11.2%, тэтгэвэрт гарснаас хэнд ч хэрэггүй мэт санагдах 9.7%, үр хүүхэдтэйгээ муу харилцаатай 5.4%, материаллаг хэрэгцээний дутагдал 5.2% тус тус илрэв. Судалгаанд хамрагдсан настны дундаж наслалт 64.1 байсан [95% CI: 62.1–65.2]. Эдгээр оролцогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд (56.3%), тэдний дөрөвний гурваас илүү нь тэтгэвэрт гарсан эсвэл ажиллах боломжгүй

хүмүүс байв. Настны талаас бага хувь нь гэрлээгүй (48.3%), бүрэн дунд боловсролтой (44.6%) байв. Ахмад настнуудын дөрөвний нэгээс бага хувь нь ерөнхий эрүүл мэндийг "Муу" гэж мэдээлсэн (28.8%), тэдний бараг 80% нь одоогийн сэтгэлийн хямралаас өөр архаг өвчтэй, ихэвчлэн тамхи татдаггүй (91.2%), анхан шатны тусламж үйлчилгээ авдаг (94.7%), жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг (87.1%) байна.

Тохируулсан логистик регрессийн загварын үр дүнгээс үзэхэд хүйс (эмэгтэй: AOR: 1.52 [95% CI: 1.07–2.17]), үндэс угсаа (Халх: AOR: 1.79 [95% CI: 1.09–2.96]; Казак: AOR: 2.48 [95% CI: 1.53–4.02]), боловсрол (бүрэн дунд: AOR: 1.49 [95% CI: 1.05–2.10]), ерөнхий эрүүл мэнд ("Муу": AOR: 2.12 [95% CI) : 1.42–3.17]), тамхи татдаг байдал (тамхи татдаг хүмүүс: AOR: 1.72 [95% CI: 1.07–2.76]), эрүүл мэндийн асуудлын улмаас тусгай тоног төхөөрөмж ашигладаг (Тийм: AOR: 1.64 [95% CI: 1.13-2.39]) зэрэг нь тодорхойлогдлоо.

Хэлцэмж: Сэтгэл гутралд хүргэх шалтгааны хувьд хөгжингүй орнуудад амьдарч буй настны хувьд ганцаардал, хавсарсан өвчин эзэлж байна.[6] Нас дагаж дотоод шүүрлийн тогтолцоонд гарах өөрчлөлтийн улмаас сэтгэл гутрал үүсдэг буюу нэн ялангуяа амигдала, гиппокампид гарсан өөрчлөлтийн улмаас сэтгэл гутрал үүсдэг гэж үзжээ.[6,7] Гэр бүлийн хэн нэгэн гишүүнээ алдсан уй гашуйн дараа настанд хийгдсэн Когорт судалгаагаар сэтгэл гутрал судалгаанд оролцсон бүх оролцогчдод илэрч байсан бөгөөд үүний 48%-нь уй гашуу тайлах эмчилгээгээр илааршсан байна. Уг судалгааны ажлын зарим үр дүн нь бидний судалгааны ажилтай дүйж байгаа юм.[8]

Дүгнэлт:

1. Настанд тохиолдох сэтгэл гутралын тэргүүлэх шалтгаанд хагацлын дараах уй гашуу буюу гэр бүлийн хэн нэгэн гишүүнээ алдсан уй гашуу эзэлж байна.
2. Сэтгэл гутралтай настанд уй гашуу тайлах эмчилгээ хийх нь өвчний тавиланд сайнаар нөлөөлж болох юм

Ном зүй:

1. *Taylor WD (2014). "Клиникийн практик. Ахмад настнуудын сэтгэлийн хямрал". New England Journal of Medicine. 371 (13): 1228–36.*
2. *Alexopoulos GS, Kelly RE (2009 оны 10-р сар). "Ахмадын сэтгэл гутралын талаархи судалгааны ахиц дэвшил". Дэлхийн сэтгэл судлал. 8 (3): 140–9.*
3. *Teffens DC, Potter GG (2008 оны 2-р сар). "Гэрийн сэтгэлийн хямрал ба танин мэдэхүйн сулрал". Сэтгэл зүйн анагаах ухаан. 38 (2): 163–75.*
4. *Mitchell AJ, Subramaniam H (2005 оны 9-р сар). "Дундад насныхтай харьцуулахад хөгшрөлтийн сэтгэл гутралын таамаглал: харьцуулсан судалгааны системчилсэн тойм". Америкийн сэтгэцийн эмгэг судлалын сэтгүүл. 162 (9): 1588–601.*
5. *Кришнан КР (2007 оны 1-р сар). "Ахмадын сэтгэцийн эмгэгийн тухай ойлголт". Америкийн ахмад настны сэтгэцийн эмгэг судлалын сэтгүүл. 15 (1): 1–11.*
6. *Алексопулос GS (2005). "Ахмад настнуудын сэтгэлийн хямрал". Лансет. 365 (9475): 1961–70.*
7. *Yohannes AM, Baldwin RC (2008). "Хожуу үеийн сэтгэлийн хямрал дахь эмнэлгийн хавсарсан өвчин". Сэтгэцийн цаг. 25 (14).*
8. *Harlow S. D, Goldberg E. L, and G. W. Comstock, "A longitudinal study of risk factors for depressive symptomatology in elderly widowed and married women," American Journal of Epidemiology, vol. 134, no. 5, pp. 526–538, 199.*

Identifying etiology that contribute to depression in the elderly

Ayuurzana A[1], Uranzaya M[2], Batkhuu B[1]

[1]Department of Family Medicine, MNUMS
[2]4th Student, MNUMS
E-mail: ayurzana@mnums.edu.mn, Tel: 98010138

Background: By 2030, the elderly aged 65 and over will make up 11.9 percent of Mongolia's population, and by 2050 this population will reach 21.1 percent.
Aim: To identify the factors that contribute to the development of depression in the elderly.
Objective: The aim of this study was to identify depression from participants and to identify the factors that contribute to depression.
Materials and Methods: In this study, we have received a questionnaire from the clients at the Ulemj-Eej private clinic to identify the factors that contribute to depression.
Results: Depression accounted for 37% of family losses, 23.2% of loneliness, 11.2% of chronic illnesses due to old age, 9.7% of people who felt useless after retirement, 5.4% of poor relationships with children, and 5.2% of lack of material needs.
Discussion: In a cohort study, depression was found in all participants, with 48% recovering from grief relief therapy.
Conclusion: Complicated grief is more likely to cause depression and may be more effective in relieving grief.

Keywords: Depression, old age, grief, loneliness, chronic illness